ДИПЛОМАТ ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ АВСТРИЙН ХОЛБООНЫ ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИИН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Австрийн Холбооны Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар (цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэх) Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын дипломат паспорт эзэмшигчийн харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов.

1 дугээр зүйл
Визийн шаардлагаас чөлөөлөх

1. Монгол Улсын хүчин төгөлдөр биометрик мэдээлэл бүхий дипломат паспорт эзэмшигч иргэд Бүгд Найрамдах Австри Улс, эсхүл 1985 оны 6 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Хилийн шалган нэвтрүүлэх ажиллаагааг үе шаттайгаар цуцлах тухай Шенгений гэрээг хэрэгжүүлэх 1990 оны 6 дугаар сарын 19-ний Шенгений конвенц”-ын аль нэг оролцогч улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсон өдрөөс эхлэн нэг зуун ная (180) хоногийн хугацаанд ер (90) хоног визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

2. Хүчин төгөлдөр биометрик мэдээлэл бүхий дипломат паспорт эзэмшигч Австри Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчихдоо Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсон өдрөөс эхлэн нэг зуун ная (180) хоногийн хугацаанд ер (90) хоног визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

2 дугаар зүйл
Нэвтрэн орох, гарах нөхцөл

Хэлэлцэн тохирогч холбогдох Талуудын хууль тогтоомжид аюулгүй байдал, цагаачлал, гааль, ариун цэвэр болон бусад заалтаар хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд хэлэлцэн тохирогч Талуудын харьяатын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн аль нэг шалган нэвтрүүлэх цэгээр Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хүчин төгөлдөр биометрик мэдээлэл бүхий дипломат паспорт эзэмшигчид саадгүй нэвтэрч, эсхүл гарч болно.

3 дугаар зүйл
Урт хугацаанд оршин суух, хөдөлмөр эрхлэх

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн заалтууд аль нэг Талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэхээр зорих, эсхүл 1 дүгээр зүйлд заасан хугацаанаас илүү хугацаанд оршин суухаар төлөвлөж байгаа иргэнд үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл
Эрх ямба, дархан эрх эдлэгч иргэд

Олон улсын эрх зүйн дагуу хүлээн авагч улсаас олгосон үнэмлэх эзэмшиж, эрх ямба, дархан эрх эдлэгч иргэн нэг Талын нутаг дэвсгэрт оршин суух, эсхүл дахин нэвтрэхэд Монгол Улс, эсхүл Бүгд Найрамдах Австри Улсын хүчин төгөлдөр биометрик мэдээлэл бүхий дипломат паспорт болон үнэмлэхтэй тохиолдолд виз болон оршин суух зөвшөөрөл авахгүй.

5 дугаар зүйл
Мэдээлэлд тавигдах шаардлага

1. Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш гуч (30) хоногийн дотор энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасны дагуу өөрсдийн ашигладаг гадаад паспортын загваруудыг дипломат шугамаар харилцан солилцоно. Мөн Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь шинэчилсэн, эсхүл өөрчилсөн дипломат паспортын загварыг тухайн паспортыг олгохоос хамгийн багадаа гуч (30) хоногийн өмнө нөгөө талдаа хүргүүлнэ.

2. Хэлэлцэн тохирогч Талууд паспорт олгохтой холбоотой өөрсдийн үндэсний хууль тогтоомжид орсон аливаа өөрчлөлтийн талаар тухай бүр харилцан мэдэгдэнэ.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг улсын иргэн энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр паспортоо нөгөө Талын нутаг дэвсгэрт гээгдүүлсэн тохиолдолд энэ тухайгаа хүлээн авагч талын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Холбогдох дипломат төлөөлөгчийн газар, консулын газар нь дээрх иргэнд шинээр паспорт, аяллын баримт бичгийг олгож, хүлээн авагч талын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

6 дугаар зүйл
Эрх, үүрэг

1. Энэхүү хэлэлцээр нь аль нэг хэлэлцэн тохирогч Талын иргэдийг нөгөө хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн оршин суух, хилээр нэвтрэх болон гарахтай холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргээс чөлөөлөхгүй.

2. Хэлэлцн тохирогч Тал бүр нийтийн амгалан тайван байдал, эрүүл мэнд, эсхүл үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй, сэжигтэй гэж үзсэн этгээдийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэхээс татгалзах, эсхүл тэдгээрийн оршин суух хугацааг богиносгох эрхтэй.

7 дугаар зүйл
Түдгэлзүүлэх

Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь нийтийн дэг журам, үндэсний аюулгүй байдал, олон нийтийн эрүүл мэнд, хууль бус цагаачлал, эсхүл буцаан хүлээн авахтай холбоотой хамтын ажиллагаа байхгүйн улмаас энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг түр хугацаагаар түдгэлзүүлж болно. Түдгэлзүүлэх болон уг хэлэлцээрийг дуусгавар болгох тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

8 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлах явцад үүссэн аливаа маргааныг Талууд эвтэй байдлаар зөвлөлдөөний аргаар дипломат шугамаар шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл
Нэмэлт, өөрчлөлт

Хэлэлцэн тохирогч Талууд харилцан тохиролцсоноор энэхүү хэлэлцээрт бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлтийг тусад нь протокол үйлдэн хэлэлцээрийн салшгүй хэсэг болгон баталгаажуулах бөгөөд 10 дугаар зүйлд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох, дуусгавар болох

1. Энэхүү хэлэлцээр нь Талууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн дагуу хэлэлцээрийг хүчин төгөлдөр болох шаардлагуудыг бүрэн хангасан тухайгаа дипломат шугамаар хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа харилцан мэдэгдсэн сарын дараах сар буюу хоёр дахь сарын эхний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Хэрэв Монгол Улсын Засгийн газар болон Австрийн Холбооны Засгийн газар хоорондын “Хууль бусаар оршин сууж буй иргэдийг буцаан шилжүүлэх тухай хэлэлцээр”-ийн хүчин төгөлдөр болох огноо нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт

заасан өдрөөс хойш байгаа тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийг үл харгалзан, энэхүү хэлэлцээр Хууль бусаар оршин сууж буй иргэдийг буцаан шилжүүлэх тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсонд тооцно.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь энэхүү хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлээ бичгээр хэдийд ч нөгөө талд дипломат шугамаар мэдэгдэн хэлэлцээрийг цуцалж болно. Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийг нөгөө тал хүлээн авснаас хойш гурван сарын дараа хэлэлцээрийг дуусгавар болсонд тооцно.

..... хотноо ..... оны ..... дугаар/дүгээр сарын ..... өдөр монгол, герман, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэлэлцээрийн заалтуудыг тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

АВСТРИЙН ХОЛБООНЫ ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ